


**НИЙСЛЭЛИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 1/14

Улаанбаатар хот

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг үнэн бодит тоон мэдээлэл, судалгаанд суурilan шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд гарч байгаа анхан шатны суурь мэдээллийг нэгтгэн гаргаж, салбарын өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх бодлого төлөвлөлтийг тодорхойлох чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

М.Цогзолмаа (Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга)

Ажлын хэсгийн гишүүд:

С.Саранцэцэг (Спорт, нийтийн биеийн тамирын хэлтсийн дарга)

Ажлын хэсгийн
нарийн бичгийн дарга:

Э.Мөнх-Эрдэнэ (Спорт, нийтийн биеийн тамирын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Б.Оюунтуяа (Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн)

А.Намуун (Эрхзүй, тогтоол, шийдвэр хариуцсан мэргэжилтэн)

Н.Өлзийжаргал (Хэвлэл мэдээлэл, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Г.Бямбасайхан (Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

2. Байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд гарч байгаа анхан шатны суурь мэдээллийг нэгтгэн гаргаж, салбарын өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх бодлого төлөвлөлтийг тодорхойлсон саналыг 2024 оны 04 дүгээр сарын 15-ны дотор боловсруулж Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж ажиллахыг Ажлын хэсэг (Г.Бямбасайхан)-т үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын хэсэг (М.Цогзолмаа)-т даалгасугай

